



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.02.28 № 06/44
танай _____ -ны № _____ -т
Г _____ Г

Г
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Н.ЛХАГВА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг, хариуцлага

Норовлин сумын Засаг даргын Тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт,

түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 70562147
Цахим хаяг:

Аудитор: Н.Туяа
Утас: 70562147
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн
сум 3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас:
Khentii@audit.gov.mn

2018 оны 02 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

158

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/75/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Н.Туяа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 08-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 02 дугаар сарын 08 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.1.1.-д сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргийг "харьяалах нутаг Дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл

зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах,...” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн төрийн сангаас олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим, нарийвчилсан сорил 5-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг

хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт зарим талаар хангалтгүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 267.4 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 267.4 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 34.4 сая төгрөгийн санхүүжилтийн, үйл ажиллагаанаас 1.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн 33.4 сая төгрөг зарцуулан, 1.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийг шалгахад хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн санхүүгийн тайланг мэдээлэхдээ хагас дутуу, шаардлага хангахгүй мэдээлэл оруулсан, 17 мэдээллийг хугацаа хоцроож, санхүүжилтийн орлогыг бөөн дүнгээр мэдээлсэн байна. Энэ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 5 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Засгийн газрын тогтоол, шийдвэр, заавар журам болон нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөхгүй байх нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

161

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 2017 онд батлагдсан орон тооноос илүү малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн ажиллуулж 3-12 сард 4160,9 мянган төгрөгийн цалин олгож, Төсвийн тухай хуулийн 16.5.3 “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтад нийцээгүй, УИХ-ын 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

Аудитаар материаллаг бус зөрчил илэрсэн байна.

2. Малын дансанд хэрэгжүүлсэн сорилоор малын нас дэвшилтийг бүрэн хийгээгүй, 4,894,0 мянган төгрөгийн мал худалдан авсан, худалдан борлуулсан баримтын бүрдүүлэлт хангалтгүй, туслах аж ахуйн тооцоог хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалт болон санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөх.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дараагийн аудитаар шалгахад шийдвэрлэв.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

162

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 9.1 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн ба 4.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 4.9 сая төгрөгийн 2 зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, хавсралтууд 4 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

Хянасан:

Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Бэлтгэсэн:

Ахлах аудитор



/ Ч.Эрдэнэбаатар/

/ Д.Оюунтуяа/

/ Н.Туяа/

Огноо: 2018.02.28

Аудитын зөрчлийн нэгтгэлийн хүснэгт

Байгууллагын нэр: Норовлин сумын ЗДТГ

/мянган төгрөг /

Д/д	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа			Нийт зөрчил				Нийт алдаа зөрчил	Тайлбар
		Нийт дүн	Залруулсан	Залруулаг даагүй	Нийт дүн	Акт	Албан шаардлага	Зөвлөмж		
1	2017 онд батлагдсан орон тооноос илүү малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн ажиллуулж 3-12 сард 4160,9 мянган төгрөгийн цалин олгож, Төсвийн тухай хуулийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтад нийцээгүй, УИХ-ын 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.				4160.9		4160.9		4160.9	
2	Малын дансанд хэрэгжүүлсэн сорилоор малын нас дэвшилтийг бүрэн хийгээгүй, 4,894,0 мянган төгрөгийн мал худалдан авсан, худалдан борлуулсан баримтын бүрдүүлэлт хангалтгүй, туслах аж ахуйн тооцоог хийгээгүй байна.				4894.0			4894.0	4894.0	
3	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийг шалгахад хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн санхүүгийн тайланг мэдээлэхдээ хагас дутуу, шаардлага хангахгүй мэдээлэл оруулсан, санхүүжилтийн орлогыг бөөн дүнгээр мэдээлсэн, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.									зөвлөмж өгсөн
Дүн		0.0	0.0	0.0	9054.9	0.0	4160.9	4894.0	9054.9	

Бэлтгэсэн: Ахлах аудитор:

Менежерийн санал:

Н.Туяа

Огноо: 2018.02.28

Анхан шатанд хянасан менежер:

Дарга, Тэргүүлэх аудиторын санал:

Д.Оюунтуяа

Огноо:

2018.2.28

Хоёр дахь шатанд хянасан

дарга, тэргүүлэх аудитор:

2317144297
СНДА0046 9074082

Ч.Эрдэнэбаатар

Огноо:

2018.2.28



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 12 дугаар сарын 28

Дугаар 01

Чингис хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.1-д тодорхойлсон Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Норовлин сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

2017 онд батлагдсан орон тооноос илүү малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн ажиллуулж 3-12 сард 4160,9 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх ..." МУ-ын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.3-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн", 4.1.5 "Байгуулсан гэрээ хэлцэл, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага нөхцлийг хангаагүй"- д Төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

- ЗДТГазрын холбогдох ажилтнуудын ажлын ачааллыг нягтруулан зохион байгуулж, шинээр нэмэгдүүлсэн орон тоог цомхотгон, биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Норовлин сумын ЗДТГ-ын дарга Н.Лхагвад даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газрын
Ахлах аудитор

Н.Туяа

ЗӨВШӨӨРСӨН:

Норовлин сумын
ЗДТГ-ын дарга

Н.Лхагва

¹ Албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлдэггүй тохиолдолд" зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ гэж зарсны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газар

**НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Нягтлан бодох бүртгэл тайлагналын талаар3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар4

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Лхагва, нягтлан бодогч Л.Энхдорж нарт талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

1. Малын дансанд хэрэгжүүлсэн сорилоор малын нас дэвшилтийг бүрэн хийгээгүй, 4,894,0 мянган төгрөгийн мал худалдан авсан, худалдан борлуулсан баримтын бүрдүүлэлт хангалтгүй, туслах аж ахуйн тооцоог хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалт болон санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

АГ-ын зөвлөмж

1. Малын дансны орлого, зарлага, ашиг шимийн тооцоог бодон холбогдох баримтыг зохих ёсоор бүрэн бүрдүүлж, нас дэвшилтийн зөрүү, үр дүнг бүртгэлд үнэн зөв тусгаж ажиллах.

Эрсдэлүүд

Орлого, зарлагыг бүрэн бүртгэхгүй байх, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх, холбогдох хууль журам, стандартыг мөрдөхгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Хууль тогтоомжийн хэрэгжилт

Тэргүүлэх ач холбогдол №2

АГ-ын ажиглалт

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийг шалгахад хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн санхүүгийн тайланг мэдээлэхдээ хагас дутуу, шаардлага хангахгүй мэдээлэл оруулсан, 17 мэдээллийг хугацаа хоцроож, санхүүжилтийн орлогыг бөөн дүнгээр мэдээлсэн байна. Энэ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

АГ-ын зөвлөмж

1. Шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулах, батлагдсан төсвийг хэтрүүлэх, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх


Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:


ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.ЭРДЭНЭБААТАР
Д.ОЮУНТУЯА

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



Н.ТУЯА

